



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 08 сарын 28 өдөр

Дугаар 01/118

Номгон

Шүүгчийн захирамж биелүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 5-ны 17/59 дүгээр аймгийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөө батлах тухай тогтоолын 2 дугаар хавсралтын 30 дахь заалт, Баянхонгор аймаг дахь Сум дундын Иргэний хэргийн анхан шатын шүүхийн Шүүгчийн 131/ШШ2023/00419 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Иргэн Д.Рэнцэнцэдэвийн нэхэмжлэлтэй шүүх хурлын маргаан бүхий Номун далай цогцолбор сургуулийн хуучин хичээлийн байрыг буулгах ажлыг гүйцэтгэсэн боловч техникийн тодорхойлолтоос бодит барилгын байдал зөрүүтэйгээс гадна эд хөрөнгийн доголдолтой нөхцөл байдлуудаас шүүхийн маргаан үүсэж хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэнтэй холбогдуулан нэхэмжлэлийн шаардлага бүхий нийт 90,000,000 төгрөгөөс энэ онд 30,000,000 сая төгрөгийг аймгийн 2024 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-д зөвшөөрсүгэй.

2.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч/Б.Батсуурь /-д даалгасугай



ДАРГА ~~МОНХСАЙХАН~~

02.11.2024